



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№108 /552/

2023.07.07

Цаг үе, үйл явдал

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ТОХИОЛДУУЛАН ОФИЦЕР, АХЛАГЧ, АЖИЛТАН АЛБА ХААГЧ, АХМАДУУДАА ШАГНАЖ УРАМШУУЛАВ



Тулгар төр үүсэн байгуулагдсаны 2232 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жилийн ойн Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан эл өдөр Батлан хамгаалах салбар офицер, ахлагч, ажилтан алба хаагч, ахмадуудаа шагнаж урамшууллаа. Уг ёслолын ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын дэд сайд

Б.Баярмагнай, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг нар оролцож улс орноо батлан хамгаалах үйлсэд залуу халуун нас, хөдөлмөр зүтгэлээ хоёргүй сэтгэлээр зориулан ажилласан ахмад дайчид болон өдгөө албандаа үр бүтээлтэй ажиллаж буй нийт 50 гаруй офицер, ахлагч, ажилтан алба хаагчдад Төрийн дээд одон, медаль болон Батлан хамгаалах салбарын шагналыг гардуулсан юм. Дэслэгч Ө.НАСАНТОГТОХ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 11

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	🌧️ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,438	3,445
EUR 🇪🇺	3,740	3,750
CNY 🇨🇳	479.20	481
RUB 🇷🇺	37.50	38.50
JPY 🇯🇵	23.80	24.50
KRW 🇰🇷	2.63	2.65

ЗУРХАЙ



ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН БАР ӨДӨР

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.01-20.53

Барилдлага:

Шид

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Тийн мэдэхүй

ЗЭВСЭГТ ХҮЧИН ХЭЗЭЭД БЭЛЭН БАЙДАГ



Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн эх орноо батлан хамгаалах ариун үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэхийн зэрэгцээ хуулиар хүлээсэн байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослоос хүн ам, эд баялгийг авран хамгаалахад дэмжлэг үзүүлэх болон бусад олон талт үүргийг амжилттай биелүүлсээр ирсэн юм.

Энэ өдрүүдэд нийслэл хотноо зарим дүүрэгт үүсээд буй байгалийн давагдашгүй хүчин зүйл болсон үерийн усны аюулаас хүн ам, эд баялгийг авран хамгаалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, далан шуудууны сэтэрсэн хэсэгт хаалт тавих, сэргээн босгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

Уг гамшигийн хор хохирлыг арилгахын төлөө төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нэгэн зорилгын дор өдөр, шөнө, ядрал алжаалыг үл умартан, дайчин шуурхай ажиллаж буйд иргэд сэтгэл хангалуун байгаа юм.

Эх орон, төр, ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнч

байж, иргэдийнхээ айх аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг нь бүрдүүлэхийн төлөө чин сэтгэлээсээ зүтгэж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, түүний дотор Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдаа баяр хүргэж, улам их амжилтыг бэлгэдэн ерөөе.

Тэд ямар ч үед хэзээд бэлэн байдаг.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



ҮЕРИЙН ДАЛАН БОСГОХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



Нийслэлд их хэмжээний аадар бороо орсны улмаас хэд хэдэн байршилд үерийн гамшиг нүүрлэсэн. Зэвсэгт хүчний томилгоот бүрэлдэхүүн өглөөний 06:00 цагаас эхлэн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Туул голд нийлдэг хэсэгт үерийн далан босгох ажлыг Хилийн цэргийн алба хаагчидтай хамтран гүйцэтгэж байна. Үерийн усны түвшин нэмэгдэж байгаагаас гадна замын түгжрэлээс үүдэн элс, шороо татах ажилд хүндрэл үүсэж байгааг албаныхан хэллээ.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,205,828

Эдгэрсэн

Нийт: 663,755,771

Нас барсан

Нийт: 6,898,266

Цахим шууданд

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН БАГА ЧУУЛГАНЫ ГИШҮҮНИЙ ГЭРЧИЛГЭЭ, ЭНГЭРИЙН ТЭМДЭГ ОЛГОЛОО



Монгол Улсын Шинжлэх ухааны академийн салбаруудын бага чуулганы 2023-2024 оны нөхөн сонгууль саяхан явагдсан билээ. Тэгвэл өнөөдөр нөхөн сонгуулиар сонгогдсон гишүүдэд Монгол Улсын Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн хурлын 2023 оны 06 дугаар

сарын 26-ны өдрийн 17/23 дугаар тогтоолын дагуу бага чуулганы гишүүний гэрчилгээ, энгэрийн тэмдэг олгогдолоо. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (БХЭШХ)-ээс нэр дэвшсэн тус хүрээлэнгийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн эрдэм шинжилгээний

тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор О.Үржин Шинжлэх ухааны академийн "Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулган"-ы гишүүнээр, мөн хүрээлэнгийн Дайн, цэргийн урлаг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цэргийн ухааны доктор (Ph.D), дэд профессор С.Пүрэвдорж Шинжлэх ухааны академийн "Хими, биологийн салбарын бага чуулган"-ы гишүүнээр тус тус сонгогдож, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч, Академич Д.Рэгдэл болон Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч, Академич Г.Чулуунбаатар нараас гишүүний гэрчилгээ, энгэрийн тэмдэг хүлээн авлаа.

Шинжлэх ухааны академийн салбарын бага чуулганы гишүүнээр томилогдсон эрдэмтдийнхээ цаашдын эрдэм, судлалын ажил үйлсэд амжилт хүсэж, эрүүл энх, саруул сайхан байхын өлзийтэй ерөөл өргөн барья.

БХЭШХ

ШАТАЛСАН ДАМЖААНУУД АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ДУУСЛАА



2022-2023 оны хичээлийн жилд Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн материаллаг баазыг түшиглэн даргалах албан тушаалын ахлагчийн шаталсан сургалтын "Бүлгийн даргын дамжаа"-г 4 багц цагаар буюу 1 сарын хугацаатайгаар зохион байгуулан явуулж, 52 ахлагч, "Тасгийн захирагчийн дамжаа"-г 12 багц цагаар буюу 3 сарын хугацаатайгаар зохион байгуулан явуулж, 59 ахлагч, "Рот /батарей/-ын ахлагчийн

дамжаа"-г 4 багц цагаар буюу 1 сарын хугацаатайгаар зохион байгуулан явуулж, 50 ахлагчийг, мөн Зэвсэгт хүчний "Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2024"-ийн хүрээнд Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн "Тасгийн захирагчийн дамжаа"-г 12 багц цагаар буюу 3 сарын хугацаатайгаар зохион байгуулан явуулж, 59 ахлагч, нийт 220 ахлагчийг амжилттай төгсгөлөө.

БХМСҮТ-ийн мэргэшүүлэх сургалтын дамжаа нь суралцаж төгссөн бүрэлдэхүүний мэдлэг, үр

чадварыг дээшлүүлэхийн зэрэгцээ албан тушаалд дэвшин ажиллах нөхцөлийг хангадаг нь онцлог юм.

"Рот /батарей/-ын ахлагчийн дамжаа"-ны VII дахь удаагийн төгсөлтийн "Шилдэг суралцагч"-аар Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Р-142 радио станцын дарга Ахлах ахлагч Д.Сүрэн шалгарлаа.

Төгсөлтийн арга хэмжээний үеэр БХМСҮТ-ийн шаталсан сургалтыг төгсөж буй ахлагч нарт Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар албан тушаалын цол олгогдож, гэрчилгээ, энгэрийн тэмдгийг ЗХЖШ-ын ахлагч тэргүүн ахлагч Н.Баасан, БХМСҮТ-ийн захирал дэд хурандаа Э.Батгэрэл нар гардуулан өгөв.

Ахлах ахлагч Н.НАРАНЦЭЦЭГ



Гэрэл зураг түүх өгүүлнэ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД ҮЕРИЙН ГОЛОМТОД АЖИЛЛАЖ БАЙНА

САЛБАРЫН ХАМТ ОЛОН НЬ ИЖ БҮРЭН ӨРГӨӨ ЦАГААН ГЭР БЭЛЭГЛЭЖ, ГЭРЛЭХ ЁСЛОЛЫГ НЬ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 143 дугаар тусгай салбарын хамт олон салбарынхаа энгийн ажилтан Х.Энхсайхан /уурын зуухны галч/-д иж бүрэн өргөө цагаан гэр барьж өгч, гэрлэх ёслолын ажиллагааг Баянхонгор аймгийн Баянговь сумын Соёлын төвд билэгт сайн өдөр зохион байгууллаа.

Гэрлэх ёслолыг уламжлалт ёс заншлаар хийж, хуримын бөгж солилцох, гэрлэлтийн бүртгэлд гарын үсэг зуруулах гэрчээр салбарын бие бүрэлдэхүүн, хосуудын төрөл төрөгсөд оролцсон юм.

Салбарын хамт олны нэг болсон залуу хосууд нь аав, ээжийн халуун хайраас бага насандаа салж бүтэн болон хагас өнчирч хорвоогийн хатуу бэрхийг туулж өссөн ч нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгийн төлөө гэсэн уриатайгаар хамт олны хайр халамж дор дутуу зүйлгүй өрх гэрийг босгож, энхрий бяцхан хоёр сайхан үр хүүхдүүдэд аз жаргал, баяр хөөртэй байх орчныг бүрдүүлжээ.

Гэрлэх ёслолын ажиллагааг нээж тус салбарын захирагч хошууч Д.Батмөнх хэлэхдээ бид иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутагт Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, сум орон нутагт манлайлан ажиллах, залуу гэр бүлийг дэмжих, нийгмийн хариуцлагын хүрээнд залуу хосуудын өргөө цагаан гэрийг сүндэрлүүлж, гэрлэх ёслолын ажиллагааг зохион байгуулж байна.

Хамт олон бидний энэхүү санаачилсан энэхүү ажил, арга хэмжээнд өөрсдийн санаачилгыг гаргандэмжлэг үзүүлсэн өргөө гэрийн модыг шийдвэрлэж өгсөн Баянговь сумын Иргэдийн хурлын хамт олон, бусад эд материалаар дэмжлэг үзүүлсэн тус сумын "Багачууд цэцэрлэг", Онцгой байдлын Эрэн хайх аврах бүлэг, ММГ ХХК, Баянговь сумын 8 жилийн сургуулийг 1994 оны 14 дүгээр төгсөлт, 2008 оны 33 дугаар төгсөлтийн хамт олонд болон сумын гуравдугаар багийн Засаг дарга Д.Түвшиндалай, Монгол Улсын аварга малчин Ц.Бат-Эрдэнэ, малчин Ж.Сайнбаяр, Баянлиг сумын малчин Ч.Мөнхдалай нарт талархлын сэтгэгдлээ салбарын нийт бүрэлдэхүүнийхээ өмнөөс илэрхийлэе. Шинэхэн айлыг аз жаргал, тав тухтай амьдрахын төлөө тэмүүлэх итгэлийн очийг асааж, алдрай бяцхан үрсийн ая тухтай өсөж бойжих орчин нөхцөлийг бүрдүүлэх бэлтгэл ажлыг цаг зав, сэтгэл зүрхээ гарган ажилласан салбарын офицер, ахлагч, ажилтан албан хаагчдадаа бид нэг хамт олон гэдэг нь энэхүү ажлын үр дүнгээс харагдаж байна гэсэн юм.

Гэрлэх ёслолын арга хэмжээг хөдөө орон нутагт анх удаа тайз чимэглэлтэйгээр сүйн бөгжийг солилцуулан, үндэсний ёс заншлаа дээдлэн зохион байгуулсан нь сум орон нутгийн иргэдийн сэтгэлд ихэд хүрч, санаа зорилгоо нийлүүлсэн сайхан хамт олон хэмээсэн талархлын сайхан үгсийг сумын удирдлага, иргэдээс хүртсээр байна.

Сургагч ахлагч С.МӨНГӨН

ҮЕРИЙН УСАНД ИДЭГДСЭН ДАЛАНГ ЗАСВАРЛАЖ БАЙНА



Үерийн усны улмаас гамшиг мэдээллийг албаныхан өглөө. Зэвсэгт үүссэн Чингэлтэй дүүргийн 26 дугаар хүчний томилгоот бүрэлдэхүүн хороонд Зэвсэгт хүчний томилгоот яг одоо шуурхай арга хэмжээ авч, шуудайгаар бэхлэлт босгон, үерийн бүрэлдэхүүн үүрэг гүйцэтгэж байна. Тус хороонд байрлах Нямдоржийн усанд идэгдсэн даланг засварлаж гүүрний далан үерийн усанд идэгдэж, цагийн байдал хүндэрсэн талаарх байна.